

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024.04.26

№01

Улаанбаатар хот

Тооллогын Комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас
ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй
2. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - Х.Баттуул
 - Х.Цэндбаяр
 - Б.Саруул
 - Б.Намуун
 - Le Goff Didier
 - Чэн Ха Ен нарыг

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр :

- Д.Баярсайхан
- Т.Золбаяр
- Б.Оргил нарыг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгосугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг 81,000,000 төгрөгөөр баталсугай.

4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 400 төгрөгөөр тогтоосугай гэж тогтоолыг уншиж танилцуулсанаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ажиллагаа өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

Б.БУРМАА



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024.04.26

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурал, хурал хийхээр товлосон товын дагуу 2024.04.26-ны өдрийн 14цаг 00 минутад Компанийн хурлын танхимаас цахимаар шууд дамжуулав.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2024.04.26-ны өдрийн " Хүчин төгөлдөрт тооцох тухай" №01 тоот тогтоолыг тооллогын комиссын дарга Ү.Номин уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалынр хуудсанд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга Ү.Номин : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд ширхэг хувьцаа эзэмшсэн 1.023.703 ш хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий ширхэг хувьцаа эзэмшсэн хувьцаа эзэмшигч ирсэн байна. Энэ нь нийт хувьцааны % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв.

Үүний дараа хурал даргалагч байраа эзлээд хурлын дэг , Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг танилцуулж ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батлах
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 400 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :
 1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг компанийн Гүйцэтгэх захирал Л.Баттөр илтгэв.
 2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг ерөнхий нягтлан бодогч Эрдэнэцэцэг тайлагнав.
 3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн товч тайлан, 2024 оны төсөв болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн "Ногдол ашиг хуваарилах" тухай тогтоолыг танилцуулав.

Асуулт: - Хувьцаа эзэмшигч Жаргал

Компанийн амжилтын нууц, хэрэглэгчидийг өөртөө татдаг давуу тал юу вэ?

Хариулт: Үйлдвэрлэл хариуцсан Ерөнхий менежер Ч.Энхтуяа:

Анх 1984 оноос хойш үйлдвэрлэж буй Атар талх, хотол бялуу зэрэг бүтээгдэхүүнүүд одоо ч гэсэн хэрэглэгчидийн өдөр тутам хэрэглэж байгаа тухайн бүтээгдэхүүний орц найрлага, технологийн горим болон стандартын мөрдөлттэй холбоотой өөрийн гэсэн өвөрмөц амт чанараа хадгалж ирсэн.

Энэ онд манай компаний Итали болон Испани, Португали улсад үйлдвэрлэгдсэн шинэ тоног төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж байгаа тун удахгүй хэрэглэгчиддээ шинэ бүтээгдэхүүн гаргахад бэлэн болсон

Түүнчлэн ажилтнуудын хөдөлмөр хөнгөвчлөгдөн, бүтээмжийг нэмэгдүүлэхүйц давуу талууд үүснэ

Өглөө бүр 100 гаруй түгээлтийн машинаар нийслэл төдийгүй хөдөө орон нутгийн хэрэглэгчидийн хүссэн гурилан бүтээгдэхүүнийг амт чанартай үйлдвэрлэн хүргэхээр 1000 гаруй ажилтнууд маань өөрийн сонгосон мэргэжил, ажилдаа бахархалтайгаар ажилладагт манай компанийн гол нууц оршдог.

Асуулт: - Хувьцаа эзэмшигч Ц.Оюунчимэг

Энэ жил 40 жилийн ой тохиож байгаан байна, энэ бол хүнээр идэр нас цаашид хийхээр төлөвлөсөн томоохон ажлууд юу байна?

Хариулт: Маркетингийн албаны дарга Б.Энхдэлгэр

ТЧК үүсгэн байгуулагдсаны түүхт 40 жилийн ой энэ онд тохиож байгаа, бид ойн хүрээнд хэд хэдэн ажлуудыг хийхээр төлөвлөсөн,

Үүнээс Хүнс үйлдвэрлэгчдийн дунд Спортын 5 төрөлт тэмцээн, Монгол улсын Бялуу чимэглэх ур чадварын уралдаан, ажилчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулахад чиглэсэн ISO 45001 стандарт хэрэгжүүлж, Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгалыг дэмжин бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг тогтмол барихад чиглэн ISO 22000 стандартын дараагийн үе шат болох FSSC рүү шилжин нутагшуулах зэрэг ажлуудыг хийж эхлээд байна.

Өнгөрсөн 2023 онд гэхэд манай компанийн 87 ажилтан Итали улсын Siger, БНХАУ-ын Shanghai expo, Canton fair, ХБНГУ-ын IBA зэрэг үзэсгэлэн худалдаанд оролцуулж, техник, технологийн чиглэлээр гадаад харилцагч компанийн үйлдвэр дээрх сургалтад хамруулсан, цаашдаа тухайн албан тушаал, ажилтанд чиглэсэн хувь хүний хөгжил, ур чадварыг сайжруулах дотоод болон гадаад сургалт тогтмол хийгдэнэ.

Хурлын дарга : Өөр санал хүсэлт байхгүй тул санал хүсэлтийг үүгээр тасалъя. Та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Ү.Номин “ Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах” тухай тогтоолыг уншиж танилцуулав.

Компанийн нийт 1.023.703 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3.960 хувьцаа эзэмшигчдээс хуралд 884.372 ширхэг хувьцаа эзэмшсэн 103 эзэмшигч оролцов. Тооллогын комисст ирсэн саналын хуудас 103 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын хуудасны тоо 103 ширхэг, асуулга тус бүрээр хүчингүй саналын хуудас байхгүй.

1. Компаний 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 884.372 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
2. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 884,372 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй,
3. Компанийн ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг 81.000.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 884,372 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь , татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.

Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

- Le Goff Didier-ийг сонгохыг зөвшөөрсөн 883,591 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,91 хувь, татгалзсан 781 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,09 хувь, түдгэлзсэн санал байхгүй.
- Х.Баттуулыг сонгохыг зөвшөөрсөн 885,888 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100,17 хувь, татгалзсан түдгэлзсэн санал байхгүй.
- Х.Цэндбаярыг сонгохыг зөвшөөрсөн 886,986 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100,3 хувь, татгалзсан түдгэлзсэн санал байхгүй.
- Б.Намууныг сонгохыг зөвшөөрсөн 1.077.729 ширхэг хувьцаа буюу нийт саналын 121,86 хувь, татгалзсан 299 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,03 хувь , түдгэлзсэн санал байхгүй.
- Б.Саруулыг сонгохыг зөвшөөрсөн 884,034 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,97 хувь, татгалзсан 299 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,03 хувь, түдгэлзсэн санал байхгүй
- Чэн Ха Ен-г сонгохыг зөвшөөрсөн 689,665 ширхэг хувьцаа буюу нийт саналын 77,98 хувь, татгалзсан 194,707 ширхэг хувьцаа буюу нийт саналын 22,02 хувь, түдгэлзсэн санал байхгүй.

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр :

- Д.Баярсайханыг сонгохыг зөвшөөрсөн 883.803 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,94 хувь, татгалзсан 569 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,06 хувь, түдгэлзсэн санал байхгүй
- Б.Оргилыг сонгохыг зөвшөөрсөн 883,802 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,94 хувь, татгалзсан 570 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,06 хувь, түдгэлзсэн санал байхгүй.
- Т.Золбаярыг сонгохыг зөвшөөрсөн 883,811 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,94 хувь, татгалзсан 561 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,06 хувь , түдгэлзсэн санал байхгүй

4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 4000 төгрөгөөр хувиарлахыг зөвшөөрсөн 884.372 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан түдгэлзсэн санал байхгүй.

Нийт ирсэн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ: Дээрх хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай гэж танилцууллаа.

Тооллогын Комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас №01 тоот тогтоол гаргав.

Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй
2. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр :

- Le Goff Didier
- Х.Баттуул
- Х.Цэндбаяр
- Б.Намуун
- Б.Саруул
- Чэн Ха Ен нарыг


Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр :

- Д.Баярсайхан
 - Б.Оргил
 - Т.Золбаяр нарыг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгосугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг 81.000.000 төгрөгөөр баталсугай.
 5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 400 төгрөгөөр тогтоосугай гэж тогтоолыг уншиж танилцуулсанаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ажиллагаа өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА


Б.БУРМАА

ТЭМДЭГЛЭСЭН


М.ОЛШИЙБАЯР